



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 20


Сүхбаатар сум

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн
хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг "Хангалттай" гэж үнэлсүгэй.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг сэтгүүл, дүрст мэдээлэл болон хэвлэл мэдээллийн бусад хэлбэрээр иргэд, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны дарга, аймгийн Засаг даргын орлогч /Б.Нарантуяа/-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАА